



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 24-йн
алдаа

Дуглас 9/581

Мандалтөв

Г Аймгийн аварга тариаланч шалгаруулах
журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 202 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Аймгийн аварга тариаланч шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн аварга тариаланчид нэр дэвшүүлсэн тариаланчдын материалыг жил бүрийн 1 дүгээр сарын 1-ны дотор сумдаас авч 1 дүгээр сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал) -д даалгасугай.



48801073



Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын
24-ны өдрийн 15:00-т хамгаахад энэхүү журмын зорилго оршино.

**АЙМГИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН,
ТАРИАЛАНЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хөрс хамгаалах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний чанар экологийн цэвэр байдлыг хадгалах болон нийгэмд оруулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хувь нэмрийн урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Энэхүү журмын шаардлага шалгур үзүүлэлтийг хангасан нэг хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг сүүлийн турван жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн "Аймгийн тэргүүний тариаланч хамт олон", нэг иргэний сүүлийн турван жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн "Аймгийн тэргүүний тариаланч"-аар жил бүр шалгаруулна.
- 1.3. "Аймгийн тэргүүний тариаланч хамт олон", "Аймгийн тэргүүний тариаланч"-ийг жил бүр шалгаруулан цол, шагнал олгох асуудлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнз.

Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага

- 2.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь 5 -аас дээш жил тариалангийн үйлдвэрлэл тогтвортой эрхэлсэн байх
- 2.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь 5 га-аас доошгүй, иргэн нь 3 га-аас доошгүй өөрийн эзэмшлийн эргэлтийн талбайтай байх ба талбайгаа бүрэн ашиглаж нэгжээс авах ургацын хэмжээг тогтмол нэмэгдүүлж, здийн засгийн хувьд бие даан үйлдвэрлэл явуулах чадвартай болсон байх
- 2.3. Сүүлийн турван жил дараалан, жил бүр га тутмаас хураан авсан төмс 150 цн-ээс, үндэс үрт ногоо 100 цн-ээс, сонгинолог ургамал 80 цн-ээс, хамгаалагдсан хөрсний 1 метр квадрат талбай тутмаас хураан авсан өргөст хэмх 14 кг, улаан тооиль 8 кг, гүзээлзэн 2 кг, навчт ногоо 2 кг-аас доошгүй байх
- 2.4. Хураан авсан бүтээгдэхүүнээ дахин боловсруулах, хадгалах талаар зохих дадлага туршлага эзэмшсэн, ургацаа хадгалах өөрийн зоорьтой байх
- 2.5. Өөрийн эзэмшлийн талбайг бүрэн ашиглаж хөрсний үржил шимиг хамгаалах, чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн байх
- 2.6. Эрт ургацын ногоо тариалах 360 м2-аас доошгүй талбай бүхий хулэмжтэй байх
- 2.7. Гуравас доошгүй хүнийг ажлын байраар хангаж өрхийн орлогыг нь нэмэгдүүлсэн байх
- 2.8. Хугацаа хэтэрсэн өр зээлгүй, татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь телсэн байх
- 2.9. Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний газартай болж техникийн бэлэн байдал, хангамжийг сайжруулсан байх
- 2.10. Татвар хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь телсэн байх
- 2.11. Нийгмийн хариуцлагаа хулээж баг, сум, аймаг, орон нутагтаа тодорхой хувь нэмэр оруулсах байх.

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах

- 3.1. Сумын тэргүүний тариаланч хамт олон, сумын тэргүүний тариаланч болсноос хойш гурваас доошгүй жил амжилттай ажилласан энэхүү журмын шалгур үзүүлэлтийг хангасан нэг хүртэлх тариаланч хамт олон, байгууллага болон тариаланчийг тухайн сумын Засаг даргын Тамгын газраас аймгийн тэргүүний тариаланчаар шалгаруулахаар тодорхойлж, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл, сумын Засаг даргын тодорхойлолт, хүсэлтийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор багтаан Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлна.

3.2. Аймгийн тэргүүний тариаланч хамт олон, аймгийн тэргүүний тариаланчаар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах материалыг бурдүүлнэ:

- Тариаланчийн товч анкет (энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу)
- Сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт (энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу)
- Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажил байдлын талаарх сумын Засаг даргын тодорхойлолт
- Сум, аймаг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, санал дүгнэлт, сумын Засаг даргын хүсэлт
- Харилцагч татварын байгууллагын тодорхойлолт, орлогын татвар төлвлөлийн баримт
- Аймгийн ХХААГ-аас хөрс хамгаалах талаар авсан арга хэмжээ, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн тухай тодорхойлолт, шалгаруулах үзүүлэлтийг газар дээр нь шалгасан дүгнэлт

3.3. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тэргүүний тариаланч хамт олон, тариаланчид тодорхойлон сумас ирүүлсэн материалыг нэг бүрчлэн хянан үзэж, энэ журмын шаардлага, шалгур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий нэг аж ахуйн нэгж, байгууллага, нэг тариаланчийн тодорхойлолт, холбогдох материалыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хургуулнэ.

3.4. Энэ журмын шалгуурыг хангасан тариаланч хамт олон, тариаланчдын материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

3.5. Иргэн, аж ахуй нэгжийг "Аймгийн тэргүүний тариаланч"-аар зөвхөн нэг удаа шалгаруулна.

Дөрөв. Шагнал олгох

4.1. Аймгийн тэргүүний тариаланч хамт олон тус бүрийг 500000 (Таван) зуун мянга төгрөгөөр, Аймгийн тэргүүний тариаланч тус бүрийг 300000 (Гурван) зуун мянга төгрөгийн үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшуулна.

4.2. Аймгийн тэргүүний тариаланч хамт олонд "Өргөмжлөл", дурсгалын цом, Аймгийн тэргүүний тариаланчид цолны үнэмлэх, энгэрийн тэмдэгийг олгоно.

4.3. Шагналын нийт зардлыг аймгийн Засаг даргын неөц сангаас гаргаж зарцуулна.

4.4. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний ёмне гардуулна.



Аймгийн Засаг даргын оны 10 дугаар сарын
2018 нахиадын 10 захирамжийн 10 хавсралт

АЙМГИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧААР ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА ИРГЭНИЙ ТОВЧ АНКЕТ



ОН САР ӨДЕР

1	Аймаг, сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцгийн /эх/ нэр	
4	Нэр	
5	Төрсөн он, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо, тэдний зэрэлж байгаа ажил	
8	Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
9	Тариаланчаар ажилласан хугацаа	
10	Төр, засгаас авсан шагнал, огноо	

Гарын үсэг

/

/



Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын
24-ны өдрийн 10/12/2018 захирамжийн 3.. хавсралт

**АЙМГИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН; АЙМГИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ
ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлт	Онууд			Тайлбар
 он он он	
1. Тариалангийн эргэлтийн талбай /га/ Үүнээс: -тариалсан //				
2. Таримлын төрөл				
3. Хураан авсан ургац, нэр төрлөөр /тонн/ Үүнээс: -неөөцелсэн үр /тонн/ -зах зээлд борлуулсан ургац /тонн/				
4. Нэг га-гийн ургац, нэр төрлөөр /тарьсан талбай цн-эр/				
5. Нийт борлуулалт /сая.төг/ Үүнээс: -тэлсэн татвар /сая.ter/ -даатгалд /сая.төг/				
6. Ашиг сая, төг				
7. Ажлын байрны тоо				
8. Нийгмийн даатгалын шимтгэлд тэлсэн орлого /мян.төг/				

Тайлбар: Энэ хүснэгтэд зөвхөн суулийн 3 жилийн тариалангийн үзүүлэлтийг бичнэ. Шагнагдах үндэслэлийн талаар тодорхойлолтод дэлгэрэнгүй бичиж, холбогдох байгууллагын тодорхойлолтыг үзүүлэлт тус бүрээр бүрдүүлж ирүүлсэн байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дунд бусдаас худалдан авсан болон өр төлбөрт авсан бүтээгдэхүүн /ургац/-ийг оруулж тооцохгүй

Үзүүлэлтийг гаргасан:

Сумын Засаг дарга

(.....)